



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Монгол Улсын Статистикийн Хэлтэс

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2019/ I-IX



Моделийн нэрсэн хаяг: WWW.1212.MN



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГЭМ  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

I-IX

2019

Сүхбаатар сум



Ерөнхий тэмдэглэл .....	3
АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР.....	4
I. ХҮН АМ, НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	14
1.1 ХҮН АМ.....	14
1.2 ЭРҮҮЛ МЭНД .....	15
1.3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ .....	22
1.4. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ.....	24
1.5. БОЛОВСРОЛ .....	25
1.6. ГЭМТ ХЭРЭГ.....	25
1.7. ХИЛЭЭР ОРСОН, ГАРСАН ИРГЭД.....	27
II. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	27
2.1 МӨНГӨ, ЗЭЭЛ .....	27
2.2 АЙМГИЙН НЭГДСЭН ТӨСӨВ, ТАТВАР .....	29
2.3. БИЗНЕС РЕГИСТРИЙН САН.....	32
2.4. ГАДААД ХУДАЛДАА .....	34
2.5. ҮНЭ .....	34
III. ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	37
3.1. ХӨДӨӨ АЖ АХУЙ.....	37
3.2. АЖ ҮЙЛДВЭР .....	43
IV. БУСАД .....	45



## Ерөнхий тэмдэглэл

- I. Товчилсон тэмдэглэлгээ:
- ГХ- Гэмт хэрэг
  - Х.н-Хэмжих нэгж
  - ХАА- Хөдөө аж ахуй
  - АҮ - Аж үйлдвэр
  - ЖДҮ- Жижиг дунд үйлдвэрлэл
  - СЭ - Сэлэнгэ
  - НХ – Нийгмийн халамж
  - ХЧТА-Хөдөлмөрийн чадвараа түр алдсан
  - ЖА-Жирэмсний амралт
  - ҮОМШӨ-Үйлдэрийн осол мэргэжлээс шалгаалах өвчин
  - НӨАТ-Нэмэгдсэн өртгийн албан татвар
  - ҮХЭХӨЭ- Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх
  - ГӨЭ-Газар өмчлөх эрх
  - ШША-Шүүхийн шинжилгээний алба
  - ШШГГ-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
  - НДШ-Нийгмийн даатгалын шимтгэл
- II. Саруудыг ромбо тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)
- III. Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XI зэргээр илэрхийлэв
- IV. Дараах тэмдэглэлийг ашиглав:
- ... Мэдээлэл байхгүй
  - Х Бүтцийн өөрчлөлт
  - 0.0 Маш бага тоо
  - +, - Зөрүү
  - Гүйцэтгэл байхгүй
  - \* Дахин
- "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.
- V. "Төл" нь төлөвлөгөө, "Гүйц" нь гүйцэтгэл
- VI. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100.0 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

**Төсөв:** Аймгийн төсвийн орлого зарлага нь төвлөрсөн төсвийн болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

**Ажилгүйчүүд:** Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.

**Бүртгэлтэй ажилгүй иргэд:** Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

**Нийгмийн даатгал:** нь иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчид тооцно.

**Үнэ:** Аймгийн төвийн захад борлогдож байгаа болон хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийг харуулна.

**Хэрэглээний үнийн индекс:** Өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.



**Гэмт хэрэг:** Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүй алах хэргийг, хүүхэд гэр бүл нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулав.

**Хээлтэгч мал:** Нас гүйцсэн эм малыг хамруулна.

**Зүй бусаар хорогдсон малын тоонд:** Халдвартай , халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга, цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, худаг, хавцалд унах зэрэг хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

**Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хэмжээ юм. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцоход нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2016 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

**Сэлэнгэ аймгийн нийгэм, эдийн засгийн байдал**

(2019 оны эхний 9 сарын байдлаар)

**1. НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ****1.1 Хүн ам**


2019 оны эхний 9 сарын байдлаар манай аймагт бусад аймаг хотоос бүгд 2 084 хүн шилжин ирсэн нь өмнөх оны мөн үеэс 3 (0.1%) хүнээр өссөн үзүүлэлттэй байна. Нийт шилжин ирэгсдийн 1 029 (49.4%) нь эрэгтэйчүүд, 1 055 (50.6%) нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэйчүүдийн тоо 49 (5.0%) хүнээр өсч, эмэгтэйчүүдийн тоо 46 (4.2%) хүнээр буурсан байна.

**1.2 Эрүүл мэнд**

Эхний 9 сарын байдлаар аймгийн хэмжээгээр нийт 1328 эх амаржиж, 1334 хүүхэд төрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс амаржсан эх 29 (2.2%)-өөр, амьд төрсөн хүүхэд 34 (2.6%)-өөр нэмэгдсэн байна. Төрөлтийг насны бүтцээр нь харахад 25-29 насны 377 (28.3%), 20-24 насны 309 (23.3%), 30-34 насны 339 (25.5%), 35-39 насны 203 (15.3%), 40-44 насны 29 (2.2%), 45-49 насны 1 (0.1%), 20 хүртэлх насны 70 (5.3%)-ийг тус тус эзэлж байна. Эхний 9 сарын байдлаар 1737 жирэмсэн шинээр хяналтанд орсны 82.4 хувийг жирэмсний эхний 3 сарын дотор хяналтанд авсан байна. Шинээр хяналтанд авсан жирэмсний 95.5 хувийг цусны шинжилгээнд хамруулснаас 44.2 хувьд нь сум, тосгодын эмнэлэгүүдэд гемоглобины тестээр шинжилсэн ба шинжилгээнд орсон 1737 жирэмсний 0.9 хувьд нь цус багадалт илэрчээ.

0-1 насны хүртэлх хүүхдийн эндэгдэл 7, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 5 тохиолдол тус тус бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 75.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна

Нас барсан хүний тоо 387 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 8 (2.1%) хүнээр буурсан байна. Нийт нас баралтын шалтгааны 11.1 хувь нь осол гэмтлийн, 25.6 хувь нь хорт хавдрын өвчний шалтгаантай байна. Хорт хавдрын өвчнөөр өвчлөгсөд өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар өсч, хорт хавдрын өвлөлийн нас баралт 13.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**Төрсөн эх, амьд төрсөн хүүхэд**

Халдварт өвчнөөр 519 хүн өвчилж бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 113 (17.9%)-аар буурсан байна. Нийт халдварт өвчний 58.2 хувийг бэлгийн замын халдварт өвчин, 25.8 хувийг сүрьеэ, 16.0 хувийг бусад халдварт өвчин эзэлж байна.

2019 онд нийт 303 513 үзлэг хийсний 29.0 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 22.7 хувь нь гэрийн идэвхитэй үзлэг, 27.7 хувь нь диспансерийн хяналтын үзлэг эзэлж, нийт 24 919 дуудлаганд үйлчилсний 13.4 хувийг алсын дуудлагаар үйлчилж яаралтай тусламж үзүүлсэн.




### 1.3 Хөдөлмөр

2019 оны эхний 9 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 707 болсон нь өмнөх оны мөн үеэс 58 (7.6%) хүнээр буурч, өмнөх сараас 70 (10.9%) хүнээр өссөн байна. Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 707 болсны 373 (52.8%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 55.2 хувийг ерөнхий боловсролтой, 27.0 хувийг дээд боловсролтой, 13.4 хувийг мэргэжилтэй ажилчид, 3.7 хувийг тусгай дунд боловсролтой, 0.7 хувийг боловсролгүй хүмүүс эзлэх боллоо. Шинэ ажлын байранд 662 иргэн ажилд зуучлагдсаны 223 иргэн ХАА, ан агнуур, ОАА, загас агнуурын салбарт, 122 иргэн боловсруулах үйлдвэрт, 85 иргэн барилгын салбарт, 62 иргэн худалдаа, гэр ахуйн засвар, үйлчилгээний салбарт, 44 иргэн уул уурхайн салбарт, 34 иргэн зочид буудал, зоогийн газрын салбарт, 24 иргэн төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагааны салбарт, 19 иргэн боловсролын салбарт, 49 иргэн бусад салбарт ажилд орсон байна.

Энэ сард бүртгэлтэй ажилгүйчүүдээс 135 хүн ажилд зуучлагдан орж, 73 хүн идэвхгүйн улмаас хасагдаж, 278 хүн шинээр бүртгэгдсэн байна.

#### Бүртгэлтэй ажилгүйчүүд боловсролоор




### 1.4 Нийгмийн даатгал, халамж

2019 оны эхний 9 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 16 814 тэтгэвэр авагчдад 52 761.2 сая төгрөгийг олгосон нь өмнөх оны мөн үеэс тэтгэвэр авагчид 472 (2.9%) хүнээр өсч, олгосон тэтгэврийн хэмжээ 5 546.1 (11.7%) сая төгрөгөөр өссөн байна. Тэтгэмжийн даатгалын сангаас 5 889 хүнд 2 352.1 сая төгрөгийг ХЧТА, ЖА, оршуулга, ҮОМШӨ-ны даатгалын сангаас ҮО тэтгэвэр, ХЧТА-ны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 274 хүнд 882.1 сая төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангаас 440 хүнд 599.0 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгожээ.

Нийгмийн халамжийн сангаас 40 886 хүнд 11 122.7 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг олгосон нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 2593 (6.8%) хүнээр өсч, олгосон тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ 561.8 (5,3%) сая төгрөгөөр өсчээ.

#### Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, сая.төг





**1.5 Боловсрол, гэр бүл, хүүхэд, биеийн тамир спорт**

2019 оны 9 сарын байдлаар хүүхэд хамгааллын чиглэлээр хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхэд 74 хүүхэд байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 30 (28.8%) хүүхдээр буурсан байна. Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд 60 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 26 (30.2 %) хүүхдээр буурсан байна.

Гэр бүлийн чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, иргэдэд үзүүлсэн сургалт 9, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн иргэд 632 байна.

Хүүхдийн хөгжил оролцооны чиглэлээр багачуудын дунд хүүхдийн авъяас чадварыг хөгжүүлэх чиглэлээр зохиосон 4 удаагийн арга хэмжээнд 54 хүүхэд хамрагдсан байна. Улсын чанартай уралдаан тэмцээнээс 32 хүүхэд медаль авчээ.

**1.6 Гэмт хэрэг**

2019 оны эхний 9 сарын байдлаар нийт 590 гэмт хэрэг бүртгэгдсэн өмнөх оны мөн үеэс 10 (1.7%)-аар өссөн байна. Нийт гэмт хэргийн 127 (21.5%) нь согтуугаар үйлдэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 (3.9%)-иар буурсан байна.


Иргэн болон байгууллагад нийт 1820.6 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеэс 1221.6 (1.4дахин) сая төгрөгөөр өссөн байна. Учирсан хохирлоос 555.3 сая төгрөгийг нөхөн төлүүлж, нөхөн төлөлт 30.5 хувьтай байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 240 (40.7%) нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 187 (31.7%) нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 78 (13.2%) нь байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, 38 (6.5%) нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 47 (7.9%) нь бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 44 (7.2%) нь малын хулгай байгаа нь өмнөх оны мөн үеэс 25 (2.3%)-аар өссөн байна.

**1.7 Хилээр орсон, гарсан иргэд**

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг болон Сүхбаатар боомтоор давхардсан тоогоор 514.6 мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 58.7 (10.3%) мянган хүнээр буурсан байна. Нийт зорчигчдын 400.5 (77.8%) мянга нь Монгол иргэд, 114.1 (22.2%) мянга нь гадаад иргэд байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хилээр нэвтэрсэн Монгол иргэдийн тоо 52.7 (11.6%) мянган хүнээр, гадаад иргэдийн тоо 6.0 (5.1%) мянган хүнээр буурсан үзүүлэлтэй байна.

Монгол-Оросын хилийг хялбарчилсан журмаар хил нэвтрэх эрхийн үнэмлэхээр 22 951 хүн зорчсон байна.

**Хилээр орсон гарсан иргэд**



## 2 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



### 2.1 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр энэ сард кассын цэвэр орлого 40 435.7 сая төгрөг, цэвэр зарлага 40 872.3 сая төгрөгт хүрчээ. Зээлийн өрийн үлдэгдэл 312 829.2 сая төгрөг байгаа ба үүний 2.6 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Иргэдийн мөнгөн хадгаламж 101 269.3 сая төгрөг байна.



### 2.2 Төрийн сан, татвар

2019 оны 9 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 14 940.6 сая (94.3%) төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс аймгийн төсвийн орлого 10 841.8 сая (90.3%) төгрөгийн гүйцэтгэлтэй, сумдын төсвийн орлого 4 098.8 сая (107.0%) төгрөгийн гүйцэтгэлтэй байна. 2019 оны 9 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн зарлага 62 388.5 сая (87.0%) төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлага 27 620.5 сая (81.7%), Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлага 34 767.9 сая (91.7%) төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Сумдад 9 522.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 33 045.2 сая төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг, 2 064.0 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг тус тус шилжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гүйцэтгэл 217.3 сая (68.4%) төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна.



Эхний 9 сарын байдлаар 184 аж ахуйн нэгж байгууллага шинээр бүртгэгдэж, 19 аж ахуйн нэгж, байгууллага татан буугдан нийт 3 893 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байна.

Татварын орлогын гүйцэтгэл 17 981.3 сая төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 96.8 хувьтай байна.



### 2.3 Бизнес регистрийн сан

Энэ оны байдлаар бизнес регистрийн санд 3 438 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 2 313 ( 67.3% ) нь үйл ажиллагаа явуулж байна. Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 1 348 ( 58.3% ) нь Сүхбаатар, Мандал, Ерөө суманд, 519 (22.4%) нь Сайхан, Хүдэр, Баянгол, Цагааннуур, Алтанбулаг суманд, 446 ( 19.3%) нь бусад сумдад үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагаа явуулаагүй 1 125 аж ахуйн нэгж, байгууллагын 539 (47.9%) нь үйл ажиллагаа эхлээгүй, 410 (36.4%) нь түр зогссон, 81 ( 7.2 % ) нь бүрэн зогсоосон, 95 (8.4%) нь хаяг тодорхойгүй болон бусад шалтгаантай байна.



### 2.4 Гадаад худалдаа

Сэлэнгэ аймагт 2019 оны эхний 9 сарын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт 229.4 сая америк доллар, үүнээс экспорт 3.7 сая америк доллар, импорт 225.7 сая америк доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 28.2 (14.1%) сая америк доллар, үүнээс экспорт 2.2 (2.5\*) сая америк доллар, импорт 26.0 (13.0%) сая америк доллараар тус тус өссөн байна.




### 2.5 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 9 сард өмнөх сараас 0.4 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундаа 14.2 хувь, боловсролын үйлчилгээ 11.5 хувь, орон сууц ус цахилгаан хийн болон бусад түлш 5.1 хувь, тээвэр 2.0 хувь, гэр ахуйн тавилга гэр ахуйн бараа 1.5 хувь, согтууруулах ундаа тамхи мансууруулах бодис 0.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.4 хувиар буурахад хүнсний бараа согтууруулах бус ундаа 1.0 хувь, согтууруулах ундаа тамхи мансууруулах бодис 0.2 хувь, тээвэр 0.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.



### Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ:

Малын үнэ 2018 оны мөн үеэс 20.000-350.000 төгрөгөөр өссөн байна. Түүхий эдийн үнийн хувьд адууны шир 2.000 (5 дахин) төгрөг, үхрийн шир 2.000 (10 дахин) төгрөг тус тус буурсан байна.



### 3 ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ



#### 3.1 Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2018 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 726.8 мянган хээлтэгч малын 593.7 мянга (81.5%) нь 2019 оны эхний 9 дүгээр сарын байдлаар төллөсөн байна. Гүүний 70.2 хувь, үнээний 76.8 хувь, ингэний 84.9 хувь, эм хонины 83.6 хувь, эм ямааны 82.4 хувь нь төллөжээ. Мал төллөлтийн хувь Шаамар, Орхонтуул, Жавхлант сумдад өндөр буюу 96.4-99.7 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд гарсан төлийн 99.0 хувь буюу 588.5 мянган толгой төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 5.8 (0.9%) мянгаар өссөн байна.

Том малын зүй бус хорогдол 2019 оны эхний 9 сард аймгийн хэмжээнд 4.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 7.7 (2.7 дахин) мянгаар буурав. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл адуу 450 толгой, үхэр 1 111 толгой, тэмээ 1 толгой, хонь 1 598 толгой, ямаа 1 466 толгой байна. Нийт хорогдсон малын 34.5 хувийг хонь, 31.7 хувийг ямаа эзэлж байна.

2019 оны 9 дүгээр сарын ургац хураалтын явцын мэдээгээр үр тариа 33.9 мян.тн, төмс 17.1 мян.тн, хүнсний ногоо 21.6 мян.тн хураан авчээ. Үүнийг 2018 оны мөн үетэй харьцуулахад үр тариа 35.3 (48.9%) мян.тонн, төмс 12.5 (42.1%) мян.тонн, хүнсний ногоо 5.6 (20.6%) мян.тонн-р тус тус бага ургац хураан авсан байна.




#### 3.2 Аж үйлдвэр

2019 оны эхний 9 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 359.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 374.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь урьд оны мөн үеэс үйлдвэрлэлт 64.1 (21.8%) тэрбум төгрөгөөр, борлуулалт 82.8 (28.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 232.8 (62.2%) тэрбум төгрөг нь уул уурхайн салбарт, 135.0 (36.1%) тэрбум төгрөг нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 6.5 (1.7%) тэрбум төгрөг нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт салбарт бүтээгджээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт (тэрбум төг)





## 4 БАЙГАЛЬ ОРЧНЫ СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ



### 4.1 Цаг уур орчны мэдээ

#### Уур амьсгалын тойм *Climate review*

Манай орны хувьд X сард агаарын дундаж температур 1981-2010 оны дунджаар (ОЖД) ихэнх сумдын нутгаар -10С хүйтнээс +40С дулаан байдаг. Гэвч 1982, 1989, 1990, 1998, 2006, 2011, 2014, 2015 онд ихэнх сумдын нутгаар уур амьсгалын дунджаас 1.6-3.50С-аар дулаан, өдрийн үнэмлэхүй их температур 20-260С хүрч дулаарч байсан бол 1981, 1987, 2000 онд ихэнх сумдын нутгаар уур амьсгалын дунджаас 2.3-4.50С-аар хүйтэрсэн байна.

Хур тунадас уур амьсгалын \1981-2010 оны\ дунджаар X сард ихэнх сумдын нутгаар 9-15 мм хур тунадас ордог байна. Гэвч 1987 онд нийт сумдын нутгаар уур амьсгалын дунджаас 5 дахин их, 1986, 1988, 1998, 2002, 2008, 2013 онуудад уур амьсгалын дунджаас 2-4 дахин их хур тунадас орсон бол 1997, 2004 онд огт ороогүй, 1985, 1991, 2003, 2005, 2015, 2017 онд ихэнх сумдын нутгаар тун бага хур тунадас орсон байна.

Уур амьсгалын дунджаар сарын сүүлчээр 1-6 см зузаан цасан бүрхүүл тогтдог боловч цас их орсон жил 3-13 см-т хүрдэг.

Салхины хурд 16 м/с-ээс хүчтэй болох тохиолдол жил бүр 1-6 удаа ажиглагддаг бөгөөд шороон болон цасан шуурга шуурч байв.

### ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

#### *Weather forecast*

Агаарын температурын сарын дундаж нь уур амьсгалын дунджийн орчим байх төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн эхээр шөнөдөө 1 градус дулаанаас 4 градус хүйтэн, өдөртөө 12-17 градус дулаан байна. Хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр, гуравдугаар арав хоногийн эхний хагаст шөнөдөө 4-9 градус хүйтэн, өдөртөө 2-7 градус дулаан, гуравдугаар арав хоногийн сүүлчээр хүйтэрч шөнөдөө 8-13 градус хүйтэн, өдөртөө 2 градус хүйтнээс 3 градус дулаан байна. Бусад хугацаанд шөнөдөө 1-6 градус хүйтэн, өдөртөө 9-14 градус дулаан байх төлөвтэй.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ бүх сумдын нутгаар ОЖД-н орчим хур тунадас орох төлөвтэй.

Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхээр зарим сумдын нутгаар бага зэргийн хур тунадас, хоёрдугаар арав хоногийн сүүлчээр ихэнх сумдын нутгаар хур тунадас нойтон цас орно. Гуравдугаар арав хоногийн сүүлчээр зарим сумдын нутгаар цас орох төлөвтэй.

Салхи нэг ба хоёрдугаар арав хоногийн эхээр, гуравдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр зарим сумдын нутгаар 14-16 м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.

## 5 БУСАД

### а . Хяналт шалгалт

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2019 оны эхний 9 сарын байдлаар 1 181 аж ахуйн нэгж байгууллага, 222 иргэнд хяналт, шалгалт хийж, 3 265 зөрчил дутагдал илрүүлж, 1 642 зөрчил арилгуулсан байна.

2019 оны 3-р улирлын байдлаар Санхүү хяналт, аудитын алба нийт 56 аж ахуй нэгж байгууллагад хяналт, шалгалт хийж 7 063.5 мянган төгрөгийн төлбөр бүхий зөрчил илрүүлж, 210 аж ахуй нэгж, байгууллагад зөвлөмж өгч ажилласан байна.



## **б. Онцгой байдлын газрын мэдээ**

Сэлэнгэ аймгийн хэмжээнд он гарсаар 518 объект, 17 айл өрх үзлэг шалгалтанд хамрагдаж, 1 803 зөрчил илрүүлэн, 613 зөрчил дутагдлыг арилгуулсан байна. 2019 оны эхний 9 сарын байдлаар объектод 105, ой хээрийн 16 гал түймэр гарч 466.2 сая төгрөгийн хохирол учирсан байна.

## **в. Стандарт хэмжил зүйн хэлтэс**

2019 оны 3-р улирлын байдлаар 3187 хэмжих хэрэгсэл баталгаажуулснаас механик 548, цахилгаан 2157, эзэлхүүн 361, дулаан даралт 121 хэмжих хэрэгсэл байна. Бүтээгдэхүүний гэрчилгээ 7, үйлчилгээний гэрчилгээ 177 олгосон байна. Стандартын салбар сангаар 128 иргэн, аж ахуйн нэгж байгууллага үйлчлүүлсэн байна.

## **г. ШҮҮХ, ШШГАлба, ШШАлба**

Сум дундын шүүхийн мэдээгээр 3 дугаар улиралд 591 хэрэг шийдвэрлэснээс 160 (27.1%) нь эрүүгийн хэрэг, 405 (68.5%) нь иргэний хэрэг, 26 (4.4%) нь захиргааны хэрэг байна. Он гараад бүгд 173 хүн ял шийтгүүлж, 53 хүн хорих ял шийтгүүлсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд оны эхний үлдэгдэл 395 гүйцэтгэлийн материал байсан бөгөөд эхний 9 сарын байдлаар 464 материал нэмэгдэж, 62 материал хасагдсан бүгд 797 гүйцэтгэлийн материалаар 6 761.2 сая төгрөгийн өрийг барагдуулахаас 353 гүйцэтгэлийн материалаар 1 456.6 сая төгрөгийн өрийг бодитой барагдуулжээ.

ШША-ны криминалистик шинжээч нар бүгд 72 шинжилгээ хийж, 394 хэргийн газарт үзлэг хийхэд оролцсон байна. Шүүхийн шинжилгээний эмнэлэг нь эхний 9 сарын байдлаар хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ 427, цогцост шинжилгээ 148, эксгумаци хавтаст хэргийн материалаар хийсэн шинжилгээ 4, хүний биед хийсэн бусад үзлэг 39 байна.

## **д. Улсын бүртгэлийн хэлтэс**

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэлийн мэдээгээр төрөөс хувьчилсан орон сууц өмлөх эрхийн баталгаажуулалтыг 14 иргэн, газраас бусад ҮХЭХЭ-н анхны бүртгэл, баталгаажуулалтыг 423 иргэн баталгаажуулж 2 гэмтээсэн гэрчилгээг, 15 үрэгдүүлсэн гэрчилгээг тус тус шинээр олгож, 320 иргэн лавалгаа, хуулбар хийлгэж, нийт 1263 гэрчилгээ бичигдсэн байна. Мөн Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээгээр 5 702 мэдүүлэг хүлээн авч, төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг 1 452 иргэн баталгаажуулсан байна. Өмчлөх эрх шилжих гэрээ 701 хийгдсэнээс худалдах, худалдан авах гэрээ 403, бэлэглэх гэрээ 129, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөх гэрээ 74 хийгдэж, 19 үрэгдүүлсэн гэрчилгээг шинээр олгож нийт 2250 гэрчилгээ бичигдсэн байна. Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр эхний 9 сарын байдлаар нийт үйлчилгээний хураамж 156.8 сая төгрөг, ҮХЭХЭЭ-ээ худалдсанаас оруулсан татварын орлого 127.9 сая төгрөг төвлөрсөн байна.


## **е. Түүвэр судалгаа**

2019 оны 3 дугаар улирлын байдлаар Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг 306 өрхөөс, Ажиллах хүчний судалгааг 480 өрхөөс авч, судалгаанд хамрагдсан өрхүүдэд урамшуулал болгон 2970.0 мянган төгрөг олгоод байна.

**I. ХҮН АМ, НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ****1.1 Хүн ам****1.1.1 ШИЛЖИЖ ИРСЭН ИРГЭДИЙН ТОО, сумаар**

Сумын нэр	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX		2019 I-IX	
			Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Дүн	1 211	1 132	2 081	1 101	2 084	1 055
Алтанбулаг	52	54	30	15	31	19
Ерөө	55	84	99	50	117	53
Зүүнбүрэн	30	32	61	35	47	21
Мандал	218	226	761	429	685	342
Орхон	21	20	35	15	30	12
Сант	25	29	45	22	62	28
Цагааннуур	43	30	47	25	71	40
Баянгол	63	83	107	50	157	81
Сайхан	167	119	273	135	325	159
Орхонтуул	39	38	55	31	51	26
Баруунбүрэн	25	31	56	29	82	45
Шаамар	33	55	74	38	71	39
Хүдэр	31	27	30	14	53	25
Сүхбаатар	309	251	327	171	192	111
Жавхлант	39	21	17	9	34	17
Түшиг	33	8	28	15	37	20
Хушаат	28	24	36	18	39	17

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтэс

**Шилжиж ирсэн иргэдийн тоо**





## 1.2 ЭРҮҮЛ МЭНД

## 1.2.1 ТӨРӨЛТ

Сумын нэр	Төрсөн эх				<u>2019 I-IX</u> 2018 I-IX
	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	
<b>ДҮН</b>	<b>1 432</b>	<b>1 290</b>	<b>1 299</b>	<b>1 328</b>	<b>102.2</b>
Алтанбулаг	1	2	2		
Ерөө	48	31	45	30	66.7
Зүүнбүрэн	7	2	4	3	75.0
Мандал	467	459	449	459	102.2
Орхон				1	
Сант					
Цагааннуур	5	12	14	7	50.0
Баянгол	2	4	2	2	100.0
Сайхан	91	70	77	66	85.7
Орхонтуул	7	5	7	3	42.9
Баруунбүрэн	6	2	9	1	11.1
Шаамар	1	1	2	1	50.0
Хүдэр	2	3	2	2	100.0
Сүхбаатар	774	686	675	738	109.3
Жавхлант		1	1	2	2.0*
Түшиг	17	12	9	13	144.4
Хушаат	4		1		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

## 1.2.2 АМЬД ТӨРСӨН ХҮҮХДИЙН ТОО

Сумын нэр	амьд төрсөн хүүхэд								<u>2019 I-IX</u> 2018 I-IX
	2016 I-IX		2017 I-IX		2018 I-IX		2019 I-IX		
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	
<b>Бүгд</b>	<b>1 440</b>	<b>687</b>	<b>1 297</b>	<b>623</b>	<b>1 300</b>	<b>605</b>	<b>1 334</b>	<b>632</b>	<b>102.6</b>
Алтанбулаг	1	1	2	1	2				
Ерөө	48	25	32	17	46	22	31	13	67.4
Зүүнбүрэн	7	3	2	1	3	2	3	1	100.0
Мандал	475	209	464	216	449	215	463	221	103.1
Орхон							1		
Сант									
Цагааннуур	5	2	11	6	14	6	7	3	50.0
Баянгол	2		4	2	2		2	1	100.0
Сайхан	91	57	70	35	77	37	66	27	85.7
Орхонтуул	7	6	5	2	7	2	3	2	42.9
Баруунбүрэн	6	3	2	2	8	6	1		12.5
Шаамар	1	1	1		2	1	1		50.0
Хүдэр	2	2	3	2	2		2		100.0
Сүхбаатар	774	372	688	333	676	306	739	357	109.3
Жавхлант			1	1	1	1	2		2.0*
Түшиг	17	6	12	5	10	7	13	7	130.0
Хушаат	4				1				

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



**1.2.3 ТӨРСӨН ЭХ, боловсролоор**

Үзүүлэлт	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	$\frac{2019 \text{ I-IX}}{2018 \text{ I-IX}}$
<b>Бүгд</b>	<b>1 432</b>	<b>1 290</b>	<b>1 299</b>	<b>1 328</b>	<b>102.2</b>
Дээд боловсрол	267	294	306	324	105.9
Мэргэжлийн болон техникийн боловсрол	61	63	54	66	122.2
Дунд боловсрол	1005	841	873	847	97.0
Бага боловсрол	75	76	50	62	124.0
Боловсролгүй	24	16	16	29	181.3

**1.2.4 ТӨРСӨН ЭХ, насны бүлгээр**

Үзүүлэлт	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	$\frac{2019 \text{ I-IX}}{2018 \text{ I-IX}}$
<b>Бүгд</b>	<b>1 432</b>	<b>1 290</b>	<b>1 299</b>	<b>1 328</b>	<b>102.2</b>
20 хүртэлх	96	90	67	70	104.5
20 - 24	391	332	323	309	95.7
25 - 29	446	391	406	377	92.9
30 - 34	280	279	286	339	118.5
35 - 39	175	166	182	203	111.5
40 - 44	44	32	33	29	87.9
45 - 49			2	1	50.0

**1.2.5 ШИНЭЭР ХЯНАЛТАНД ОРСОН ЖИРЭМСЭН ЭХИЙН ТОО**

Сумын нэр	Шинээр хяналтанд орсон жирэмсний тоо	Үүнээс эхний 3 сартайдаа хяналтанд орсон жирэмсний тоо
<b>Дүн</b>	<b>1 737</b>	<b>1 432</b>
Алтанбулаг	62	61
Ерөө	105	88
Зүүнбүрэн	51	40
Мандал	537	444
Орхон	37	35
Сант	21	21
Цагааннуур	84	62
Баянгол	75	69
Сайхан	113	93
Орхонтуул	41	38
Баруунбүрэн	42	37
Шаамар	69	59
Хүдэр	50	50
Сүхбаатар	381	277
Жавхлант	24	23
Түшиг	28	21
Хушаат	17	14

**1.2.6 НЯЛХСЫН ЭНДЭГДЭЛ**

Сумын нэр	0-1 насны хүртэлх хүүхэд			
	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX
<b>Дүн</b>	<b>23</b>	<b>12</b>	<b>13</b>	<b>7</b>
Алтанбулаг		1		
Ерөө	2	2		
Зүүнбүрэн			1	
Мандал	5	3	2	
Орхон				
Сант				
Цагааннуур	1	2		1
Баянгол		1		
Сайхан	1		1	1
Орхонтуул				
Баруунбүрэн	1			
Шаамар	1			
Хүдэр				
Сүхбаатар	12	3	9	5
Жавхлант				
Түшиг				
Хушаат				

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Сумын нэр	1-5 насны хүүхэд			
	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>4</b>	<b>3</b>	<b>5</b>
Алтанбулаг				
Ерөө		1		
Зүүнбүрэн				
Мандал	2	1	1	1
Орхон				
Сант	1			
Цагааннуур		1		
Баянгол				
Сайхан		1		1
Орхонтуул				
Баруунбүрэн				
Шаамар	1			
Хүдэр				
Сүхбаатар	3		1	2
Жавхлант			1	
Түшиг				
Хушаат				1

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.7 НАС БАРАЛТ**

Сумын нэр	Нас баралт								<u>2019 I-IX</u> <u>2018 I-IX</u>
	2016 I-IX		2017 I-IX		2018 I-IX		2019 I-IX		
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	
<b>Бүгд</b>	<b>434</b>	<b>174</b>	<b>357</b>	<b>141</b>	<b>379</b>	<b>142</b>	<b>387</b>	<b>146</b>	<b>102.1</b>
Алтанбулаг	21	13	16	6	23	6	20	5	87.0
Ерөө	36	6	34	10	25	6	28	5	112.0
Зүүнбүрэн	11	5	8	3	9	3	8	2	88.9
Мандал	97	34	91	30	110	47	83	38	75.5
Орхон	5	4	8	3	11	2	6	1	54.5
Сант	7	3	4	2	5	2	13	6	2.6*
Цагааннуур	22	6	17	6	15	8	15	7	100.0
Баянгол	20	6	15	6	6	3	12	2	2.0*
Сайхан	36	17	25	10	32	12	32	13	100.0
Орхонтуул	14	8	12	9	8	2	15	4	187.5
Баруунбүрэн	12	3	10	5	9	5	15	9	166.7
Шаамар	20	11	17	9	17	8	17	6	100.0
Хүдэр	10	4	8	1	8	4	5	1	62.5
Сүхбаатар	108	44	83	40	80	26	101	38	126.3
Жавхлант	5	1	4		8	4	5	2	62.5
Түшиг	6	5	2		8	2	4	4	50.0
Хушаат	4	4	3	1	5	2	8	3	160.0

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.8 НАС БАРАЛТ, насны бүлгээр**

Үзүүлэлт	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	<u>2019 I-IX</u> <u>2018 I-IX</u>
<b>Бүгд</b>	<b>434</b>	<b>357</b>	<b>379</b>	<b>387</b>	<b>102.1</b>
эмэгтэй	174	141	142	146	102.8
0 - 1	23	12	13	8	61.5
1 - 5	8	5	3	4	133.3
6 - 18	12	7	7	4	57.1
19 - 54	132	112	110	104	94.5
54-с дээш	259	221	246	267	108.5

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.9 ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛИЙН НАС БАРАЛТ**

Сумын нэр	Нас баралт								<u>2019 I-IX</u> 2018 I-IX
	2016 I-IX		2017 I-IX		2018 I-IX		2019 I-IX		
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	
<b>ДҮН</b>	<b>108</b>	<b>45</b>	<b>81</b>	<b>39</b>	<b>111</b>	<b>49</b>	<b>96</b>	<b>40</b>	<b>86.5</b>
Алтанбулаг	6	2	6	3	3	1	8	4	2.6*
Ерөө	4	1	3		2	1	4	1	2.0*
Зүүнбүрэн	3	1	1		5	2	2	1	40.0
Мандал	16	8	11	8	26	12	24	9	92.3
Орхон	3	1	2		2	1	3		150.0
Сант	3	1			2	1	2		100.0
Цагааннуур	6	2	6	2	6	3	1	1	16.7
Баянгол	6	2	5	2			2	1	
Сайхан	17	9	12	7	16	6	5	2	31.3
Орхонтуул	2	1	3	2	3	1	2	1	66.7
Баруунбүрэн	7	3	3	2	2	1	4	1	2.0*
Шаамар	5	2	4	1	10	5	2		20.0
Хүдэр	3	1	4	2	5	2	2		40.0
Сүхбаатар	24	11	21	10	24	13	30	18	125.0
Жавхлант	1				1		2	1	2.0*
Түшиг	1				3		2		66.7
Хушаат	1				1		1		100.0

**1.2.10 ХОРТ ХАВДРЫН ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГСӨД**

Сумын нэр	Хорт хавдрын өвчин								<u>2019 I-IX</u> 2018 I-IX
	2016 I-IX		2017 I-IX		2018 I-IX		2019 I-IX		
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	
<b>ДҮН</b>	<b>125</b>	<b>64</b>	<b>112</b>	<b>64</b>	<b>170</b>	<b>91</b>	<b>178</b>	<b>93</b>	<b>104.7</b>
Алтанбулаг	8	4	6	3	14	9	10	5	71.4
Ерөө	11	1	4	2	11	5	8	4	72.7
Зүүнбүрэн	3	2	2	1	8	3	5	3	62.5
Мандал	21	12	19	11	24	15	43	21	179.2
Орхон	3	1	3	2	3	1	7	3	2.3*
Сант	4	2	6	4	4	3	4	1	100.0
Цагааннуур	3	1	4	2	9	4	5	3	55.6
Баянгол	8	5	2	1	6	2	7	3	116.7
Сайхан	14	8	15	8	18	10	10	7	55.6
Орхонтуул	4	3	1		8	5	3	3	37.5
Баруунбүрэн	3	2	3	2	7	3	3	1	42.9
Шаамар	3	1	6	4	7	4	6	4	85.7
Хүдэр	1		6	4	2	1	4	2	2.0*
Сүхбаатар	34	18	29	18	37	22	56	28	151.4
Жавхлант	2	2	1		5	2	3	1	60.0
Түшиг	2	1	4	2	4	2	2	2	50.0
Хушаат	1	1	1		3		2	2	66.7

**1.2.11 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГСӨД**

Сумын нэр	Бүх халдварт өвчин				<u>2019 I-IX</u>
	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	2018 I-IX
<b>ДҮН</b>	<b>1 611</b>	<b>497</b>	<b>632</b>	<b>519</b>	<b>82.1</b>
Алтанбулаг	54	29	52	34	65.4
Ерөө	95	19	27	17	63.0
Зүүнбүрэн	23	23	9	10	111.1
Мандал	543	75	94	107	113.8
Орхон	9	3	10	4	40.0
Сант	14	1	1	1	100.0
Цагааннуур	71	25	28	20	71.4
Баянгол	28	7	36	12	33.3
Сайхан	138	24	37	32	86.5
Орхонтуул	11	8	8	8	100.0
Баруунбүрэн	20	1	3	2	66.7
Шаамар	55	35	18	21	116.7
Хүдэр	49	14	10	2	20.0
Сүхбаатар	436	217	264	216	81.8
Жавхлант	25	3	8	4	50.0
Түшиг	10	9	24	10	41.7
Хушаат	30	4	3	19	6.3*

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Сумын нэр	Бэлгийн замын өвчин				<u>2019 I-IX</u>
	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	2018 I-IX
<b>ДҮН</b>	<b>292</b>	<b>256</b>	<b>431</b>	<b>302</b>	<b>70.1</b>
Алтанбулаг	19	13	41	13	31.7
Ерөө	10	4	10	6	60.0
Зүүнбүрэн	6	9	8	7	87.5
Мандал	47	38	59	55	93.2
Орхон			9	3	33.3
Сант		1	1	1	100.0
Цагааннуур	15	16	22	12	54.5
Баянгол			22	3	13.6
Сайхан	14	8	33	15	45.5
Орхонтуул	2	3	4	2	50.0
Баруунбүрэн	8			1	
Шаамар	13	21	13	16	123.1
Хүдэр	4	6	2		
Сүхбаатар	143	128	185	152	82.2
Жавхлант	2	2	4	4	100.0
Түшиг	5	6	18	9	50.0
Хушаат	4	1	0	3	

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



Сумын нэр	Гипатит				<u>2019 I-IX</u> <u>2018 I-IX</u>
	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	
<b>ДҮН</b>	<b>6</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>3</b>	150.0
Алтанбулаг			1	1	100.0
Ерөө					
Зүүнбүрэн					
Мандал	3				
Орхон					
Сант					
Цагааннуур					
Баянгол					
Сайхан					
Орхонтуул					
Баруунбүрэн					
Шаамар					1
Хүдэр	1				
Сүхбаатар	1				1
Жавхлант	1				
Түшиг					
Хушаат			1		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Сумын нэр	Сүрьеэ				<u>2019 I-IX</u> <u>2018 I-IX</u>
	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	
<b>ДҮН</b>	<b>154</b>	<b>146</b>	<b>127</b>	<b>134</b>	<b>105.5</b>
Алтанбулаг	10	12	6	15	2.5*
Ерөө	2	10	14	10	71.4
Зүүнбүрэн	1			3	
Мандал	40	33	31	41	132.3
Орхон	4	3	1	1	100.0
Сант	1				
Цагааннуур	4	9	5	5	100.0
Баянгол	12	7	13	9	69.2
Сайхан	15	10	4	12	3.0*
Орхонтуул	7	5	3	6	2.0*
Баруунбүрэн	1	1	2	1	50.0
Шаамар	6	1	3	2	66.7
Хүдэр	2	3	4	2	50.0
Сүхбаатар	49	47	31	25	80.6
Жавхлант			4		
Түшиг		3	5	1	20.0
Хушаат		2	1	1	100.0

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ****1.3.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮД**, боловсролоор

үзүүлэлт	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	$\frac{2019 \text{ I-IX}}{2018 \text{ I-IX}}$
<b>Бүгд</b>	<b>764</b>	<b>864</b>	<b>765</b>	<b>707</b>	<b>92.4</b>
Эмэгтэй	374	437	421	373	88.6
Дээд	214	306	235	191	81.3
Тусгай дунд	42	56	55	26	47.3
Ерөнхий боловсролтой	405	364	331	390	117.8
Мэргэжилтэй ажилчид	100	131	135	95	70.4
Боловсролгүй	3	7	9	5	55.6

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

**1.3.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО** сумдаар, 3-р улирлын байдлаар

Сумын нэр	Сарын эхний ажилгүйчүүд	Тухайн сард хасагдсан		Нэмэгдсэн	Сарын эцэс
		Ажилд зуучлагдсан	Идэвхгүйн улмаас хасагдсан		
<b>ДҮН</b>	<b>637</b>	<b>135</b>	<b>73</b>	<b>278</b>	<b>707</b>
Алтанбулаг	40			9	49
Ерөө	29	29		26	26
Зүүнбүрэн	6	7		39	38
Мандал	115	6	23	33	119
Орхон	5	13		11	3
Сант	22	8	2	8	20
Цагааннуур	28	8	8	28	40
Баянгол	55	12	7	24	60
Сайхан	36		5	2	33
Орхонтуул	35	10	5	21	41
Баруунбүрэн					0
Шаамар	26	2			24
Хүдэр	17	18		16	15
Сүхбаатар	196	1	23	41	213
Жавхлант	5	21		20	4
Түшиг	17				17
Хушаат	5				5

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## 1.3.3 ШИНЭ АЖЛЫН БАЙР

Сумын нэр	Бүгд	ХАА, ан агнуур, ОАА, загас агнуур	Уул уурхай, олборлох үйлдвэр	Боловсруулах үйлдвэр	Цахилгаан, дулаан, усан хангамж	Барилга	Худалдаа, гэр ахуйн засвар, үйлчилгээ	Зочид буудал, зоогийн газар	Тээвэр, холбоо	Санхүүгийн үйл ажиллагаа	мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа	Боловсрол	Эрүүл мэнд, нийгмийн халамж	урлаг, үзвэр, үйлчилгээний бусад үйл ажиллагаа
<b>ДҮН</b>	<b>662</b>	<b>223</b>	<b>44</b>	<b>122</b>	<b>2</b>	<b>85</b>	<b>62</b>	<b>34</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>0</b>	<b>15</b>	<b>24</b>	<b>19</b>	<b>8</b>	<b>15</b>
Алтанбулаг	21	6		8			2	2					2		1	
Ерөө	42	7	24	2			4						3	1		1
Зүүнбүрэн	11	8										2				1
Мандал	158	61		59			18	11				4	2	1		2
Орхон	15	11		1			1	2								
Сант	24	12		1			2						5	4		
Цагааннуур	41	4		14		2	17			3			1			
Баянгол	55	35	1	7			7	3							1	1
Сайхан	70	7		1		50	4	5		1				2		
Орхонтуул	20	7				3		2		1			5	1	1	
Баруунбүрэн	21	15		1	1			1	2						1	
Шаамар	16	3		5			2	2					2	1		1
Хүдэр	20	4		11				3								2
Сүхбаатар	65	8		9		27	3	3	1			2		5		7
Жавхлант	23	10										7	3	2	1	
Түшиг	56	25	19	2	1	3			1				1	1	3	
Хушаат	4			1			2							1		

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



**1.4. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ****1.4.1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН, сая.төг**

Үйлчилгээний төрөл	Хүн	Мөнгөн дүн, сая.төг
Халамжийн тэтгэвэр	2 560	3 590.3
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	3 313	1 577.2
Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	53	63.6
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	371	59.2
Жирэмсэн эхчүүдэд олгосон мөнгөн тэтгэмж	2 527	315.3
Ахмад дайчин, алдар цолтон ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	73	61.6
Эхийн алдар одонтой эхчүүдэд олгосон тусламж	8 787	1 149.6
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	5 324	437.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	551	136.0
Насны хишиг	4 775	719.2
Цалинтай ээж хөтөлбөр	6 299	2 199.3
Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөр	222	186.3
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	6 031	627.7
Ахмад настны хөнгөлөлт		
<b>Нийт</b>	<b>40 886</b>	<b>11 122.7</b>

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

**1.4.2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОРЛОГО, АВЛАГА, сумаар, сая.төг**

Сумын нэр	НДШ-ийн орлого			НДШ-ийн авлага		
	төл	гүй	хувь	ААНБ	төсөв	бүгд
<b>ДҮН</b>	<b>28 956.3</b>	<b>30 816.8</b>	<b>106.4</b>	<b>9 099.5</b>	<b>153.3</b>	<b>9 252.8</b>
Алтанбулаг	425.3	470.2	110.6	43.7	2.2	46.0
Ерөө	3 081.5	4 303.3	139.7	113.0	0.0	113.0
Зүүнбүрэн	297.4	310.6	104.4	29.1	0.0	29.1
Мандал	7 469.3	8 207.9	109.9	314.6	26.6	341.1
Орхон	194.6	163.2	83.9	9.1	3.3	12.4
Сант	226.8	273.5	120.6	12.2	0.0	12.2
Цагааннуур	934.1	892.5	95.6	300.0		300.0
Баянгол	618.2	638.2	103.2	191.7		191.7
Сайхан	4 852.3	3 151.0	64.9	6 600.1	15.8	6 615.9
Орхонтуул	377.8	414.7	109.8	8.0	9.4	17.4
Баруунбүрэн	360.3	401.7	111.5	110.2	7.5	117.8
Шаамар	487.3	565.9	116.1	2.7	0.4	3.1
Хүдэр	336.7	325.7	96.7	33.5	18.1	51.5
Сүхбаатар	8 462.2	9 833.3	116.2	1 267.7	49.5	1 317.2
Жавхлант	258.2	286.2	110.8	36.1	0.0	36.1
Түшиг	266.9	241.9	90.6	27.8		27.8
Хушаат	307.6	336.9	109.5		20.4	20.4

Эх үүсвэр: Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс

**1.5. БОЛОВСРОЛ****1.5.1. ХҮҮХДИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Үзүүлэлт	2019 I-IX
<b>Хүүхэд хамгааллын чиглэлээр</b>	
Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхэд	74
Хүүхэд хамгааллын үйлчилгээ авахаар хандсан хохирогч хүүхэд	16
Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо	60
Хүүхэд хамгааллын чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, иргэдэд үзүүлсэн сургалт	9
Хамрагдсан иргэдийн тоо	15 546
Гэмт хэрэгт холбогдон шалгагдаж буй насанд хүрээгүй хүмүүсийн эрхийг хамгаалан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцсон	12
Гэмт хэргийн гэрч болсон хүүхдийн эрхийг хамгаалан ЭБША-нд оролцсон	2
Хүүхдийн тусламжийн утас - 108	85
<b>Гэр бүлийн чиглэлээр</b>	
Гэр бүлийн чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, иргэдэд үзүүлсэн сургалт	4
Хамрагдсан иргэдийн тоо	937
Сэтгэл зүйн зөвөлгөө үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо	632
Гэр бүлийн хүндэтгэлийн танхимаар үйлчлүүлсэн иргэдийн тоо	33
<b>Хүүхдийн хөгжил, оролцооны чиглэлээр</b>	
Хүүхдийн авъяас чадварыг хөгжүүлэх чиглэлээр төвлөрсөн арга хэмжээний тоо	4
Оролцсон хүүхдийн тоо	54
Медаль авсан нийт хүүхдийн тоо	32

Эх үүсвэр: Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

**1.6. ГЭМТ ХЭРЭГ****1.6.1. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО**

Сумын нэр	Гэмт хэргийн тоо				2019 I-IX 2018 I-IX
	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	
<b>ДҮН</b>	<b>546</b>	<b>584</b>	<b>580</b>	<b>590</b>	<b>101.7</b>
Алтанбулаг	32	34	29	46	158.6
Ерөө	33	53	55	63	114.5
Зүүнбүрэн	11	13	10	6	60.0
Мандал	156	176	148	187	126.4
Орхон	17	20	13	10	76.9
Сант	21	9	7	10	142.9
Цагааннуур	15	10	16	17	106.3
Баянгол	6	43	36	37	102.8
Сайхан	49	57	39	37	94.9
Орхонтуул	17	16	11	16	145.5
Баруунбүрэн	14	6	18	10	55.6
Шаамар	18	10	18	15	83.3
Хүдэр	7	22	26	22	84.6
Сүхбаатар	91	94	131	92	70.2
Жавхлант	12	6	7	4	57.1
Түшиг	14	9	8	5	62.5
Хушаат	3	6	8	6	75.0

Эх үүсвэр: Аймгийн Цагдаагийн газар



## 1.6.2. БҮРТГЭГДСЭН ЗАХИРГААНЫ ЗӨРЧИЛ

Сумын нэр	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг	Бүртгэгдсэн захиргааны зөрчил бүгд	торгуульсан		Т/Х жолоодох эрх хассан
			иргэн	ААНБ	
<b>ДҮН</b>	<b>127</b>	<b>21 016</b>	<b>809</b>		<b>671</b>
Алтанбулаг	5	397	49		29
Ерөө	6	15	26		28
Зүүнбүрэн	2	46	14		4
Мандал	52	3 914	340		256
Орхон	1	373	12		15
Сант		54	19		5
Цагааннуур	3	164	9		7
Баянгол	4	6 298	47		65
Сайхан	9	3 465	51		85
Орхонтуул	3	29	8		4
Баруунбүрэн	1	102	4		3
Шаамар	4	1 484	27		11
Хүдэр	1	57	13		1
Сүхбаатар	26	379	174		154
Жавхлант	1	400	8		5
Түшиг	2	14	5		
Хушаат	2	25	3		
Бусад аймаг	1	229			

Эх үүсвэр: Аймгийн Цагдаагийн газар

## 1.6.3. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, сумдаар

Сумын нэр	Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг г/х	Өмчлөх эрхийн эсрэг г/х	үүнээс малын хулгай	Байгаль хамгаа лах журмын эсрэг г/х	Тээврийн хэрэгслийн хөд-ний аюулгүй байдлын эсрэг г/х	Бусад
Алтанбулаг	8	20	4	3	3	12
Ерөө	5	3	1	39	3	3
Зүүнбүрэн	2	2		1		1
Мандал	74	81	7	22	4	6
Орхон	5	3	1		2	
Сант	2	3	2	4	1	
Цагааннуур	6	10	1			1
Баянгол	7	10	3	3	15	2
Сайхан	9	21	10		5	2
Орхонтуул	6	8	5	1		1
Баруунбүрэн	4	3	1		3	
Шаамар	9	3	1			3
Хүдэр	5	12	5	2		
Сүхбаатар	34	51	2		2	5
Жавхлант	2	1	1			1
Түшиг	4					1
Хушаат	3	1				2
Бусад аймаг	2	8				7

Эх үүсвэр: Аймгийн Цагдаагийн газар

**1.7. ХИЛЭЭР ОРСОН, ГАРСАН ИРГЭД****1.7.1. ХИЛИЙН БООМТООР НЭВТЭРСЭН ЗОРЧИГЧ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ**

Үзүүлэлт	Орсон		Гарсан		Бүгд		2019 I-IX 2018 I-IX
	2018 I-IX	2019 I-IX	2018 I-IX	2019 I-IX	2018 I-IX	2019 I-IX	
